



ШИНЭ МОНГОЛ
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Элсэлтийн журам батлах тухай

Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, “Босго оноо тогтоох тухай” 2026 оны А/34 тоот тушаал болон бусад тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2026-2027 оны хичээлийн жилд Шинэ монгол технологийн их сургуульд бакалаврын сургалтын хөтөлбөрт тэнхимийн болон тэнхимийн бус сургалтад “Оюутан элсүүлэх журам”-ыг баталсугай.
2. 2026-2027 оны хичээлийн жилийн Элсэлтийн комиссын бүрэлдэхүүнийг баталсугай.
3. Элсэлтийн журмыг 2026 оны 09 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж, мөрдөн ажиллахыг Элсэлтийн комисс, Сургалтын албаны мэргэжилтэн /Ж.Эрдэнэчимэг/-т тус тус үүрэг болгосугай.
4. Сургалтын төлбөрийг зохих журмын дагуу тооцоо хийж хүлээн авахыг нягтлан бодогч /Б.Мөнхзул /-д үүрэг болгосугай.
5. Элсэлтийн журмын дагуу ур чадварын шалгалт авахыг Б.Эрдэнэзул, Ж.Очбаатар нарт үүрэг болгосугай.
6. 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/18 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

ЗАХИРАЛ

ДИТАНТУУЛ





ШМТИС-ИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Шинэ Монгол Технологийн Их Сургууль (ШМТИС)-ийн бакалаврын хөтөлбөрт 2026-2027 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шударга зохион байгуулах, элсэгчдэд тавих шаардлагыг тодорхойлох, элсэлтийн бүртгэл, шалгаруулалттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Элсэлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, “Босго оноо тогтоох тухай” 2026 оны А/34 тоот тушаал, Дээд боловсролсын сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам батлах тухай А/216 тоот тушаал болон бусад холбогдох эрх зүйн актыг удирдлага болгоно.
- 1.3. ШМТИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсүүлэх хяналтын тоог сургуулийн Удирдах зөвлөлөөр батлуулна.
- 1.4. Шийдвэр гаргалт: Энэхүү журмаар нарийвчлан зохицуулаагүй асуудлыг Элсэлтийн комисс хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар хэрэглэнэ.
 - Бүртгүүлэгч гэж ШМТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэх хүсэлт гаргаж, системд бүртгүүлсэн иргэн;
 - Элсэгч гэж хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулж, сургалтын гэрээ байгуулсан иргэн, шилжин ирсэн оюутан болон КООСЭН-ээс дэвшин суралцагч;
 - Хяналтын тоо гэж тухайн хичээлийн жилд I түвшинд элсүүлж болох оюутны дээд хязгаар;
 - Элсэлтийн систем гэж элсэлтийн үйл ажиллагааны цахим бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (<http://nmit.edu.mn/mn/admission>);
 - Элсэлтийн комисс гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар ШМТИС-ийн Захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг.

ГУРАВ. ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН БҮТЭЦ БА ЧИГ ҮҮРЭГ

- 3.1. Элсэлтийн комисс нь дараах бүтэцтэй байна:
 - Дарга: Сургуулийн захирал (Ерөнхий удирдлагаар хангах);
 - Нарийн бичгийн дарга: Үйл ажиллагааны зохицуулалт, бичиг баримтын бүрдүүлэлтийг хариуцна;
 - Гишүүд: Тэнхимийн эрхлэгч нар, Захиргаа, Сургалтын албаны төлөөлөл (Мэргэжил сурталчлах, тэтгэлэг болон ур чадварын шалгалт хариуцах).
- 3.2. Элсэлтийн комиссын чиг үүрэг:
 - Элсэлтийн маркетинг, зар сурталчилгааны стратеги, төлөвлөгөөг батлах;
 - Ур чадварын шалгалт авах хуваарь гаргах, шалгалтын комиссыг томилох;
 - Бүртгүүлэгчдийн ЭЕШ-ын оноог БҮТ-ийн мэдээлэлтэй тулгах, тэтгэлгийн эрхийг хянах;
 - Элсэлтийн баталгаажуулалтын хураамжийг хүлээн авч, сургуулийн мөргч бүтээгдэхүүнийг тараах;

- Сургалтын гэрээ байгуулах, мэдээллийн системд (NMIT, XCloud) оюутны эрх нээх.

ДӨРӨВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ

- 4.1. Элсэлтийн бүртгэлийг дараах процессын дагуу хийнэ.
 - 4.1.1. Цахим бүртгэл /Урьдчилсан/
 - Бүртгүүлэгч <http://nmit.edu.mn/mn/admission> системд нэвтэрч, хувийн мэдээллээ оруулна;
 - Сонирхож буй хөтөлбөрөө сонгож, ЭЕШ-ын оноогоо системд баталгаажуулна;
 - 4.1.2. Мэргэжлийн шалгалт /Шаардлагатай хөтөлбөрүүдэд/
 - Архитектурын хөтөлбөрийг сонгосон элсэгчдээс товлосон хугацаанд ур чадварын шалгалт (хар зураг) авах;
 - Комисс шалгалтын дүнг системд шивж оруулах;
 - 4.1.3. Тэтгэлэг олголт ба зөвлөгөө
 - Онооны дарааллаар эсвэл олимпиадын амжилтаар тэтгэлэгт хамрагдах боломжтой эсэхийг комисс хянаж баталгаажуулах бөгөөд тэтгэлэгийн хувь хэмжээг ШМТИС-ийн “Тэтгэлэг олгох журам”-ыг баримталж шийдвэрлэнэ;
 - Мэргэжил сонголтын талаар тэнхимийн багш нар нэмэлт зөвлөгөө өгөх;
 - 4.1.4. Баталгаажуулалт
 - Сургууль дээр биеэр ирж сургалтын гэрээтэй танилцан гарын үсэг зурна.
 - Бүрдүүлэх материалуудыг (гэрчилгээ, батламж, зураг гэх мэт) нарийн бичгийн даргад хүлээлгэж өгнө;
 - Баталгаажуулалтын төлбөр /1 кредит/ оюутнаар төлүүлнэ;
 - 4.1.5. Оюутны эрх нээх
 - NMIT, XCloud системд оюутны код, нууц үгийг идэвхжүүлэх;
 - 8 сарын 25-ны дотор төлбөр төлж, чиглүүлэх сургалтанд хамрагдах, систем, оюутны клуб зэрэг сургалтын үйл ажиллагаатай холбоотой урьчилсан зааварчилгаа олгох;
 - ШМТИС-ийн мерч бүтээгдэхүүн, гарын бэлэг өгнө.
 - 4.1.6. Хичээлийн жил
 - Төлбөр төлж хичээл сонголт хийх;
 - Оюутан чиглүүлэх сургалтанд хамрагдах;
 - Хичээл эхлэх;

ТАВ. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА БА БОСГО ОНОО

- 5.1. Элсэхийг хүсэгч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх ба ЭЕШ-ын үндэсний болон сургуулийн босго оноог хангасан байна.
- 5.2. Дэд бакалавр, бакалаврын зэрэгтэй иргэн, Коллеж болон КООСЭН төгсөгч, олон улсын шалгалтын оноотой иргэд холбогдох дүйцүүлэлтээр элсэж болно.
- 5.3. Технологийн КООСЭН төгсөгчдийг IV курст элсүүлэх шалгуур шаардлага:
 - Ярилцлага хийх;
 - Сургалтын хөтөлбөрийн агуулгыг тохиролцох;
- 5.4. 2026-2027 оны хичээлийн жилд элсэлт авах бакалаврын хөтөлбөр болон хөтөлбөрт харгалзах ЭЕШ-ын хичээл болон босго оноо:

Хүснэгт 1

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	Суралцах жил	ЭЕШ-ын хичээл 1 (Босго оноо)	ЭЕШ-ын хичээл 2 (Босго оноо)
1	061302	Програм хангамж	4	Математик, Физик (490)	Нийгэм судлал, Англи хэл (450)

2	061301	Компьютерийн ухаан	4	Математик, Физик (490)	Нийгэм судлал, Англи хэл (450)
3	061204	Өгөгдлийн ухаан	4	Математик, Физик (490)	Нийгэм судлал, Англи хэл (450)
4	073204	Барилгын инженерчлэл	4	Математик, Физик (490)	Нийгэм судлал, Англи хэл (450)
5	073104	Архитектур	4-5	Математик, Физик (490)	Ур чадвар (490)
6	071501	Механик инженерчлэл	4	Математик, Физик (490)	Нийгэм судлал, Англи хэл (450)
7	011401	Багш, математикийн боловсрол	4	Математик, Физик (490)	Ур чадвар (490)

ЗУРГАА. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ

- 6.1. Архитектурын хөтөлбөрт элсэгчдээс тусгай ур чадварын шалгалтыг "Хар зураг"-аар, Багш, математикийн боловсрол хөтөлбөрт элсэгчдээс ур чадварын шалгалтыг "Ярилцлага"-аар авна.
- 6.2. Шалгалтын үнэлэх удирдамжийг тухайн мэргэжлийн тэнхим боловсруулж Захирлаар батлуулна.

ДОЛОО. БҮРТГЭЛ БА БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТӨЛБӨР

- 7.1. Элсэх эрх авсан бүртгүүлэгч 06 дугаар сарын 25-наас 07 дугаар сарын 09-ний хооронд дараах материалыг бүрдүүлж ирж гэрээ байгуулах бөгөөд гэрээ байгуулагдмагц NMIT, XCloud систем дээр оюутны бүртгэл үүснэ.
 - Иргэний үнэмлэх;
 - Бүрэн дунд боловсролын гэрчилгээ;
 - ЭЕШ-ын батламжийн эх хувь;
- 7.2. Баталгаажуулалтын хураамж (1 кредит төлбөр)-ийг төлснөөр сургуулийн "Welcome Pack" бэлэг авах эрх үүсэх тул энэхүү төлбөрийг буцаан олгохгүй.
- 7.3. Сургалтын төлбөрийн үлдэгдлийг 08 дугаар сарын 25-ны дотор төлөгдсөнөөр, хичээл сонголтыг идэвхжүүлнэ.

НАЙМ. ТЭТГЭЛЭГ БА ХӨНГӨЛӨЛТ

- 8.1. ЭЕШ-ын 600 ба түүнээс дээш оноонд 30-100%-ийн хөнгөлөлт олгоно.
- 8.2. Улсын болон олон улсын олимпиадад медальт байр эзэлсэн бол 50-100%-ийн тэтгэлэг олгоно.
- 8.3. Бакалаврын хөтөлбөрийн өдрийн ангид элсэн суралцаж буй шинэ Монгол бүрэлдэхүүн сургууль, коллежийн төгсөгчдөд эхний семестрийн төлбөрийн 20%-ийн хөнгөлөлт эдэлнэ.
- 8.4. Тэтгэлгийн нөхцөл давхардвал суралцагч зөвхөн хамгийн өндөр хувьтай нэг хэлбэрийг сонгож эдэлнэ.
- 8.5. Тэтгэлэг, тусламжтай холбогдох харилцааг ШМТИС-ийн Захирлын баталсан "Тэтгэлэг олгох тухай" журмаар шийдвэрлэнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Элсэх эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

9.2. Хичээл эхэлснээс хойш 14 хоногийн дотор суралцахаас татгалзвал баталгаажуулалтын хураамжыг буцаан олгохгүй ба сургалтын төлбөрийг суралцсан хугацаагаар төлбөр суутгаж буцаан олгох бөгөөд 14 хоногоос хойш төлбөр буцаан олголт хийгдэхгүй.

АРАВ. ХАВСРАЛТ

10.1. Элсэлтийн үйл ажиллагаанд шаардагдах баримт бичгүүд

Хүснэгт 2

№	Маягтын индекс	Баримт бичгийн нэр	Үе шат	Хариуцах нэгж / албан тушаал	Тайлбар
1	26-ADM-NMIT-01	Элсэлтийн комиссын үйл ажиллагааны зураглал	Журам шинэчлэгдэхэд	Элсэлтийн комисс	Процессын зураглал
2	26-ADM-NMIT-02	Элсэгчийн анкет	Элсэлт эхлэхэд	Нарийн бичиг	
3	26-ADM-NMIT-03	Ур чадварын шалгалтын үнэлгээний хуудас	Шалгалт авах үед	Тэнхим	
4	26-ADM-NMIT-04	Олимпиадын амжилт, ЭЕШ-ын оноо дүйцүүлэх хуудас	Дүйцүүлэлт	Нарийн бичиг	
5	26-ADM-NMIT-05	Оюутан суралцуулах гэрээ	Бүртгэл баталгаажих үед	Сургалтын алба	
6	26-ADM-NMIT-06	Элсэлтийн үйл ажиллагааны тайлан	Жилд 1	Нарийн бичиг	Статистик, дүгнэлт